

Төслийн хугацаанд малчдад зохион байгуулсан танхимын сургалтыг:

- малын эрүүл мэнд
- мал эмнэлэг
- бэлчээр ашиглалт
- бизнесийн зарчим

- өрхийн санхүү бүртгэл
- хоршооны анхан шатны мэдлэг олгох гэсэн 6 бүлэг сэдвээр сургалт зохион байгуулав.

Танхимын сургалтад нийт 5 багийн 800 малчид хамрагдав.

III
ТӨСӨЛ

Таван хошуу малд тохиолдож байгаа төрөлхийн болон олдмол гаж хөгжлийн судалгаа - 2019 он

Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооноос таван хошуу малд тохиолдож байгаа төрөлхийн болон олдмол гаж хөгжлийн судалгааг 2019 онд хийв.

Судалгааны хүрээ:


- 20 аймаг
- Улаанбаатар хот

Судалгааны арга зүй

- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс асуулгаар судалгаа авах
- Гаж хөгжил, эрхтэн, тогтолцооны гажигтай гарсан тохиолдлуудад дүн шинжилгээ хийх
- Судалгаагаар илэрсэн эмгэг, гаж хөгжлийн төрлөөр дүгнэлт гаргах

Нийт мал эмнэлгийн нэгжийн 81 хувь нь буюу 819 нэгж хамрагдсан.

Судалгаагаар бүртгэгдсэн гаж хөгжлийн нийт 253 тохиолдолоос:



Судалгаагаар нийт 253 тохиолдол бүртгэгдсэн

- 218 тохиолдлыг малчид мэдээлсэн
- 35 тохиолдлыг малын эмч нар бүртгэсэн
- нийт 253 тохиолдлоос 20-д нь лабораторид дээж илгээсэн

Ургийн гаж хөгжлийн эмгэгийн тохиолдлыг ижил шинж тэмдгээр нь ангилвал 12 төрлөөр ялгах боломжтой ба нэг аймагт дунджаар 14-16 гаж хөгжлийн тохиолдол (Улаанбаатар хот ороогүй) илэрч байна.


Судалгааны асуулгаар нийт 304 ургийн гаж хөгжил тохиолдсон. Үүнд:

- 23% олон толгойтой
- 23% олон хөлтэй
- 17% хөл, үе мөчний гаж хөгжил
- 13% битүү бөгстэй



УРГИЙН ГАЖ ХӨГЖЛИЙН ТОХИОЛДОЛУУД

(аймгийн нэрээр)



Газар зүйн байршлаар авч үзвэл малын гаж хөгжил:

- Хангайн болон өндөр уулын бүсийн аймгуудад илүүтэй,
- Тал хээрийн бүсийн аймгуудад бага зэрэг,
- Говийн бүсийн аймгуудад харьцангуй бага тохиолдож байгаа нь харагдаж байна.

Малын эрхтэн, тогтолцоо болон бүтэн биед тохиолддог эмгэгүүд буюу ургийн гаралтай гаж хөгжил нь Монгол орны бүх аймгуудын нутаг дэвсгэрт тохиолдож байна.



Холбоо барих мэдээлэл: byambadolgor.luvsanjamts@orano.group

Бадрах Энержи ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян Гүний гудамж 9
АйСиСи Цамхаг, 8-р давхар,
Утас: (+976) 11 320698, 11 323400, (+976) 7011 0475, (+976) 7011 0675



Малын эрүүл
мэндийн судалгаа
Дорноговь аймгийн
Улаанбадрах болон
Сайншанд сум
2014-2019 он



I төсөл

Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах сумдын малын эрүүл мэндийн судалгаа, тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ - 2014 он

Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооноос Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах сумдын малын эрүүл мэндийн судалгаа ба тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээг 2014 оны 5-6 дугаар сард хийж гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн нутагт үйл ажиллагаа явуулдаг “Бадрах Энержи” ХХК (одоогийн нэрээр) тусгай зөвшөөрөлтэй талбайн бүсэд болон гадна амьдарч буй малчин өрхийн малын эрүүл мэндийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, Сайншанд, Улаанбадрах сумдын сүүлийн 10 жилд гарсан халдварт болон паразиттах өвчний нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн гаргах зорилгоор уг судалгаа, үнэлгээний ажлыг хэрэгжүүлэв.

Үнэлгээнд нийт 20 малчин өрх айлыг хамруулахдаа сумын удирдлагатай зөвлөлдсөний үндсэн дээр:

- “Бадрах Энержи” ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн бүсэд амьдарч байгаа 15 өрх,
- “Бадрах Энержи” ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн бүсээс гадна амьдарч байгаа 5 өрхийг хамруулсан.



Уг судалгаа, үнэлгээний ажлыг:

- Хээрийн судалгаа,
- Сүүлийн 10 жилийн буюу 2004-2014 оныг хамрах статистик мэдээнд суурилан хийсэн

I. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ

Үнэлгээ, судалгаанд нийт 474 малыг түүврийн аргаар хамруулж, эмнэл зүйн ерөнхий үзлэгийг хийсэн.

Дээрх малаас дараах төрлийн дээж авч, шинжилгээнд хамруулсан, үүнд:

- 62 малаас цусны дээж
- 46 малаас баасны дээж
- 8 малд эмгэг анатомийн бүрэн задлангийн дээж авав.

A. ЦУС, БААС, ЗАДЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН:

МАЛЫН ЦУСНЫ ИЙЛДСЭНД ЯВУУЛСАН CU, SE, CA, P, ZN, MG-ИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

		Хэвийн хэмжээнд	Хэвийн хэмжээс өндөр	Хэвийн хэмжээс бага	1 болон 2-р бүлгийн ялгаа
1.	Селени	12	9	39	1 болон 2-р бүлгийн хооронд ялгаагүй
2.	Кальци	15	0	46	1 болон 2-р бүлгийн хооронд ялгаагүй
3.	Фосфор	4	56	0	1 болон 2-р бүлгийн хооронд ялгаагүй
4.	Цайр	12	9	39	1 болон 2-р бүлгийн хооронд ялгаагүй
5.	Магнезиум	41	0	19	1 болон 2-р бүлгийн хооронд ялгаагүй

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын цусны ийлдсэнд явуулсан Cu, Se, Ca, P, Zn, Mg-ийн хэмжээг тодорхойлох шинжилгээгээр дээрх элемент харилцан адилгүй байгаа ч компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайн бүсэд болон түүний гадна амьдарч байгаа 1 болон 2-р бүлгийн хооронд ялгаа ажиглагдаагүй болно.

ПАРАЗИТ ХОРХОЙ ИЛРҮҮЛЭХ МАЛЫН БААСАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Паразит хорхой илрүүлэх шинжилгээгээр дээрх 20 өрхийн 16 малчны малын хотноос нематод буюу дугариг хорхойн хүрээхээс Trichostrongylus sp. ба Nematodirus sp. төрлийн цагаан хорхойн өндөг болон Eimeriidae язгуурын эгэл биетэн шимэгч хорхой илэрсэн.

20 малчин өрхийн 16 малчны хотноос паразит хорхой илэрсэн

- бог малын хялгасан хорхой
- бөөрөнхий хорхой
- үхрийн хялгасан хорхой
- Задлангийн шинжилгээний үр дүн:

B. ЭМГЭГ АНАТОМЫН ШИНЖИЛГЭЭ:

Малын эрүүл мэндийн тухайн үеийн нөхцөл байдлыг үнэлэх хүрээнд 1-р бүлгийн малчдын мал сүргээс 4 мал (бод 1, бог 3), 2-р бүлгийн малчдын малаас мөн 4 мал (бод 1, бог 3) нийт 8 мал сонгож аваад тус бүрт нь зориудын нядалгаа явуулж, эмгэг бие бүтцийн бүрэн задлалт үйлдсэн.

Ингээд хэвийн ба эмгэг өөрчлөлттэй эд, эрхтнүүдийг гэрэл зургаар баримтжуулан тэдгээр эд, эрхтнүүдээс эмгэг гистологийн дээж аван бэхжүүлж, эмгэг гистологийн дээж бэлтгэдэг нийтлэг арга зүйн дагуу боловсруулан гематоксилин - эозиноор будаж микроскопоор шинжилсэн бөгөөд үр дүнг гэрэл зургаар мөн баримтжуулсан.




Хонины зүрх

Хонины зүрхний тууш зүслэлт

УЛСЫН ХЭМЖЭЭН ДЭХ МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ | 2011- 2013 ОН

Судалгаагаар Дорноговь аймагт 2011-2013 онд бүртгэгдсэн халдварт өвчний гаралт улсын дунджаас доогуур байна.



II төсөл


Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах төсөл 2014 - 2017 он

Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооноос Дорноговь аймгийн Улаанбадрах сумын 4 баг, Сайншанд сумын 1 баг буюу нийт 5 багийг хамруулан малын өвчлөл ихтэй мал сүрэгт хяналт хийснээр малын эмгэгүүдийн талаар илүү ойлголттой болох мөн малчидтай хамтран ажиллах замаар малын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх төслийг 2014-2017 онд хэрэгжүүлсэн.

Төслийн үндсэн чиглэл:

- Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх
- Малчдад сургалт зохион байгуулах

Мал эмнэлгийн үйлчилгээ:



Төслийн хүрээнд мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан малын тоо




МАЛ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 239 малчин өрхөд 814 удаа очиж үзлэг хийсэн нь тус бүс нутгийн нийт малчин өрхийн 78 хувийг хамарсан. Ингэхдээ нийт 1600 малыг хамруулан үзэв.

Мал эмнэлгийн тусламж үйлчилгээ

- 239 малчин өрх
- 814 үзлэг
- нийт малчин өрхийн 78%
- нийт 1600 толгой мал

Үзлэг хийсэн малын тоо, баг багаар



Дүгнэлт:

Төсөлд хамрагдсан Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын нийт 5 багийн малчин өрхийн мал сүрэгт тохиолдож байгаа өвчлөл бусад бүс нутгийн малын өвчлөлтэй харьцуулан авч үзэхэд адил байв.

Үүнээс гадна төсөлд хамрагдсан Улаанбадрах сумын 4 баг, Сайншанд сумын 1 багийн мал сүрэгт тохиолдож байгаа малын өвчлөл, үхэл, хээл хаялт нь баг бүрт жил бүр өөр байгаа нь цаг агаарын хүчин зүйл, бэлчээрийн чанар болон малын шилжилт хөдөлгөөн, эпизоотоор тайлбарлагдана.

Төсөлд хамрагдсан мал сүрэгт хийсэн ажиглалтаар энэ бүс нутагт малын эрүүл мэндийн онц гойд асуудал байхгүйн дээр төвлөрсөн цор ганц голомт байхгүй байв.

МАЛЧИД СУРГАЛТАД ХАМРАГДАВ

